

БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ТҮВШИНЖАРГАЛ



БНХК/20240303113 ДУГААРТАЙ "БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН  
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ"  
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

**Ажлын нэр:** "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ" хийж гүйцэтгэх

**Ажлын байршил:** Улаанбаатар хот, Багануур дүүрэг

**Гэрээний төрөл:** Зөвлөх үйлчилгээ авах

**Захиалагч байгууллага:** Багануур ХК

**Гэрээний үргэлжлэх хугацаа:** 3 сар

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li><li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</li><li>- Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоол "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам"</li><li>- Дүйцүүлэн хамгааллын аргачлал</li><li>- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр тайланг боловсруулах журам</li></ul>
2	Ажлын зорилго	Багануур ХК-ийн олборлолтын үйл ажиллагаа болон түүнийг дагалдах дайвар бүтээгдэхүүн олборлох, үйлчилгээний объектууд нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөлөл, гарч болзошгүй эрсдлийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх төсөв, төлөвлөгөө боловсруулж, нарийвчилсан үнэлгээний тодорхойлолт хийх
3	Хамрах хүрээ	<ol style="list-style-type: none"><li>1. Нүүрс олборлолтын үйл ажиллагаа</li><li>2. Дайвар бүтээгдэхүүн /хайрга/ олборлох үйл ажиллагаа</li><li>3. Оффис, орон сууц, хоккей, спорт цогцолбор, тэсрэх материалын агуулахын үйл ажиллагаа</li></ol>
4	Бүтээгдэхүүн	<ol style="list-style-type: none"><li>1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ <i>Байгаль орчны төлөв байдлын тайланг гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт багтаан гүйцэтгэх</i></li><li>2. Байгаль орчны Ерөнхий үнэлгээ</li></ol>

		<p>3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /Байгаль орчны менежментийн төлөвлөгөө/</p> <p><i>Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсанаас хойш 60 хоногт багтаан гүйцэтгэх</i></p> <p>4. БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх</p>
5	Тайлагнах	<p>1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагаар батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.</p> <p>2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн танилцуулга, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, баталгааны тусгай дансны мэдээллүүд, төсөл хэрэгжүүлэгч болон зөвхөн төсөл хэрэгжих талбайн талаарх холбогдох мэдээллийг мэдээллийн санд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсанаас хойш 1 сарын дотор оруулна.</p>
6	Ажлын тайлагийн иж бүрдэл	<p>Ажлын даалгаварт тусгасан ажлын тайланг 2 хувь цаасан болон электрон хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>1. Ажил гүйцэтгэх явцад авсан фото, зураг, видео бичлэгийг эх файлаар захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан бүрэн дууссаны дараа үйл явцыг багтаасан товч тайланг файлаар хүлээлгэн өгнө. /PPT, слайд хэлбэрээр бэлтгэсэн/</p> <p>3. Ажлын тайланг электрон болон хэвлэмэл байдлаар Монгол хэл дээр 4 хувь хэвлэж акт үйлдэн хүлээлгэж өгнө.</p>

Хянасан: Танилцсан: ХАБЭАХ-ийн дарга

Боловсруулсан: Экологич инженер

Ч.Ариунбаатар

О.Мөнхуяа